

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСЭЭС 2023 ОНЫ 4 САРЫН 06-НЫ ӨДӨР ЗОХИОН БАЙГУУЛСАН “ХАРИЛЦАН
ТУРШЛАГА СОЛИЛЦОХ” АРГА ЗҮЙН СУРГАЛТЫН ТАЙЛАН**

2023 оны 04 дүгээр сарын 06

Мандалговь хот

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагийн дарга, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, цахим асуудал хариуцсан мэргэжилтэн нарын дунд зохион байгуулах “Харилцан туршлага солилцох” арга зүйн сургалтын хөтөлбөрийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Доржбатаар батлуулан хэлтэс, агентлагуудад сургалтын хөтөлбөрийг Засаг даргын Тамгын газрын даргын 02/435 тоотор хүргүүлсэн. Мөн сургалтад хамрагдах 68 албан хаагчдын нэрсийн жагсаалтыг гаргасан.

Арга зүйн сургалтыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, хууль эрх зүйн хэлтэстэй хамтран сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа. Сургалтад нийт 57 албан хаагч буюу нийт хамрагдах ёстой албан хаагчдын 83.8 хувь хамрагдсан байна. Нийт сургалтад хамрагдсан албан хаагчдын 20 нь буюу 35.7 хувь эрэгтэй албан хаагчид байлаа.

Сургалтыг 8 сэдвийн хүрээнд зохион байгуулж, цаашид анхаарах асуудалд арга зүйн зөвлөгөө өгсөн.

Сургалтад хамрагдсан байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Агентлагийн нэр	Сургалтад хамрагдах ёстой албан хаагчдын тоо	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	Үүнээс		Тайлбар
				эрэгтэй	Эмэгтэй	
1	БОАЖГ	3	3	2	1	
2	ГХБХБГ	3	3	1	2	
3	УЦУОШТ	3	3	0	3	
4	СХЗХ	3	2	1	1	
5	ХХААГ	3	2	0	2	
6	МЭГ	3	1	0	1	
7	ОНӨГ	3	2	1	1	
8	СХ	3	2	0	2	
9	СХДАА	3	3	1	2	
10	ТХ	3	1	0	1	
11	НДХ	3	2	2	0	
12	ХХҮГ	3	4	2	2	
13	ГБХЭХГ	3	2	1	1	
14	ЭМГ	3	3	0	3	
15	СУГ	3	3	0	3	
16	БТСГ	3	3	2	1	
17	БШУГ	3	3	0	3	
18	ЭМДХ	2	2	0	2	
19	УБХ	3	2	1	1	
20	ЦГ	3	3	3		
21	ШШГГ	3	2	1	1	
22	ШШХ	3	3	1	2	
23	ОБГ	3	2	1	1	
24	ТХДЖТеатр		1		1	
25	Дүн	68	57	20	37	



Харилцан туршлага солилцох арга хэмжээний хүрээнд 2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээгээр эхний 3 байранд орсон Ус цаг уур орчны шинжилгээний төв, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар зэрэг агентлагууд 2022 онд хэрэгжүүлсэн бусдад туршлага болох арга хэмжээнүүдийг танилцуулаа.



Сургалтын ирцийн бүртгэлийг хавсаргав.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС